

БАНКНЫ ЗЭЭЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь банк бусдад зээл олгоход баримтлах зарчим, тавих шаардлага, зээлийн хувийн хэргийг бүрдүүлэх, зээл олгох шийдвэр гаргах, олгосон зээлд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Банк нь зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд баримтлах Зээлийн эрсдэлийн аппетитыг тодорхойлсон байх бөгөөд зээлийн эрсдэлийн аппетит нь банкны Эрсдэлийн аппетитын бүрэлдэхүүн хэсэг байна.
- 1.3 Банк нь зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд баримтлах зарчим, шийдвэр гаргалт, хяналтын тогтолцоог тодорхойлсон зээлийн бодлоготой байх бөгөөд уг бодлогыг зээлийн эрсдэлийн аппетитын хүрээнд боловсруулна.
- 1.4 Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, боловсронгуй байдал, зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлоготой уялдуулан зээлийн хүсэлтийг судлах, зээлийн эрсдэлийг үнэлэх, зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох, зээл олгох шийдвэр гаргах, олгосон зээлийг хянах журам, заавар, арга, аргачлалыг дотооддоо боловсруулж, мөрдөж ажиллана.
- 1.5 Банк зээл олгохтой холбоотой аливаа үйл явц, үе шат, хариуцах ажилтан, түүний үүрэг, хариуцлагыг холбогдох дотоод журам, зааварт нарийвчлан зааж өгнө.
- 1.6 Зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлого, энэ журмын 1.4-д заасан журам, заавар, арга аргачлалыг банкны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) баталж, Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлж ажиллана.
- 1.7 Шаардлагатай тохиолдолд эдийн засгийн болон бизнесийн орчны нөхцөл байдалтай уялдуулан банк зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлогыг жилд 1-ээс олон удаа, шинэчлэн баталж болно.
- 1.8 Зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлого, энэ журмын 1.4-д заасан журам, заавар, арга аргачлалын хэрэгжилтэд ТУЗ-ын дэргэдэх Эрсдэлийн хороо тогтмол хяналт тавьж, улирал бүр ТУЗ-д тайлагнана.
- 1.9 Монголбанкнаас баталсан Банкны зохистой засаглалын журмын дагуу банк нь зээлийн үйл ажиллагааг зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлогын хүрээнд эрхэлж байгаа эсэхэд хяналт тавих удирдлага, засаглалын бүтэцтэй байна.

ХОЁР. Зээлийн эрсдэлийн аппетит

- 2.1 Банк зээлийн үйл ажиллагааг энэ журмын 1.2-т заасан зээлийн эрсдэлийн аппетитын хүрээнд эрхлэнэ.
- 2.2 Банкны эрсдэлийн аппетитын бодлогын баримт бичиг (Risk Appetite Framework)-ийг жил бүр Эрсдэлийн удирдлагын хорооны дэргэдэх Эрсдэлийн удирдлагын нэгж

боловсруулж, ТУЗ-өөс шинэчлэн батлах хүрээнд банкны зээлийн эрсдэлийн аппетит шинэчлэгдэн батлагдана.

- 2.3 Зээлийн эрсдэлийн аппетитын баримт бичигт дараах зүйлсийг тодорхойлно. Үүнд:
- 2.3.1 Банкны нийт зээлийн багцын бүтэц, бүрэлдэхүүн;
 - 2.3.2 Зээлийн бүтээгдэхүүн бүрийн хувьд нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээний дээд хязгаар;
 - 2.3.3 Зээлийн багцын төвлөрлийн хязгаар буюу тухайн зээлийн бүтээгдэхүүн эсхүл эдийн засгийн салбарт олгох зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийн дээд хязгаар;
 - 2.3.4 Хамтын санхүүжилттай зээлийн гэрээнд оролцох дээд хязгаар;
 - 2.3.5 Гадаад валютаар олгох зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийн дээд хязгаар;
 - 2.3.6 Зээл олгох зорилтот харилцагчдын тодорхойлолт;
 - 2.3.7 Зээл олгох зорилтот эдийн засгийн салбар;
 - 2.3.8 Зээл олгохоос зайлсхийх харилцагчдын тодорхойлолт;
 - 2.3.9 Зээл олгохоос зайлсхийх эдийн засгийн салбар, бизнесийн үйл ажиллагаа;
 - 2.3.10 Бусад шаардлагатай хязгаарлалтууд.
- 2.4 Банк зээлийн эрсдэлийн аппетитаар тогтоох зээлийн хязгаарлалтуудыг эдийн засгийн мөчлөг, хүүгийн болон зах зээлийн бусад өөрчлөлт, хөдөлгөөнийг харгалзан мэдрэмтгий байдлын шинжилгээний үр дүнд тулгуурлаж, тооцоолсны үндсэн дээр тогтооно.

ГУРАВ. Зээлийн бодлого

- 3.1 Банкны ажилтнууд нь зээлийн үйл ажиллагааны бүх шатанд зээлийн бодлогыг баримталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 3.2 Зээлийн бодлогыг Эрсдэлийн удирдлагын хорооны дэргэдэх Эрсдэлийн удирдлагын нэгж боловсруулж, ТУЗ жил бүр шинэчлэн батална.
- 3.3 Банк нь банкны зохистой үйл ажиллагаа болон Монголбанкнаас тогтоосон шаардлагын хүрээнд, өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, хүний нөөцийн болон технологийн нөөц бололцоондоо тулгуурлан зээлийн бодлогыг боловсруулна.

- 3.4 Банк нь зээлийн бодлогоор зээлийн эрсдэлийг тогтоох, үнэлэх, хянах, удирдах бодлого, зарчмыг тодорхойлж, зээлийн багцыг зээлийн эрсдэлийн аппетитын хүрээнд зохистой хэмжээнд төрөлжүүлнэ.
- 3.5 Банк нь зээлийн бодлогодоо дараах болон бусад шаардлагатай гэж үзсэн бүрэлдэхүүн хэсгийг оруулна. Үүнд:
- 3.5.1 Зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд зээл олгох шалгуур, шаардлага;
 - 3.5.2 Гадаад валютаар олгох зээлийн бодлого;
 - 3.5.3 Хамтын санхүүжилттай зээлийн гэрээнд оролцоход баримтлах бодлого, зарчим;
 - 3.5.4 Байгаль орчин, нийгмийн талаар баримтлах бодлого;
 - 3.5.5 Мөнгө угаах, терроризмыг санхүүжилэхтэй тэмцэх хүрээнд баримтлах бодлого;
 - 3.5.6 Зээл батлах үе шат, хариуцах албан тушаалтан, шийдвэр гаргах эрх бүхий зээлийн хороо(д);
 - 3.5.7 Зээлийн хороо(д)-ын шийдвэрлэх нэг зээлдэгчид олгох зээлийн дүнгийн дээд хязгаар;
 - 3.5.8 Зээлийн хороо(д)-ын шийдвэрлэх зээлийн бүтээгдэхүүний төрөл;
 - 3.5.9 Зээлийн бодлого, зээлийн эрсдэлийн аппетитад заасан хязгаарлалтаас хэтэрсэн, харьяалагдахгүй зээлийг хэрхэн шийдвэрлэх бодлого болон шийдвэрлэх дараагийн түвшний хороо(д), тэдгээрийн эрх мэдэл, шийдвэр гаргах шат дараалал;
 - 3.5.10 Зээлийн бүтээгдэхүүний хугацаа, хүүг тогтоох зарчим;
 - 3.5.11 Зээлийн хяналтыг хийх, зээлийн эргэн төлөлтийн чадамжийг үнэлэх зарчим;
 - 3.5.12 Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох зарчим;
 - 3.5.13 Банк зээлийн бодлогод тусгах шаардлагатай гэж үзсэн бусад зүйлс.
- 3.6 Банк хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх талаар зээлийн бодлогод тусгана.
- 3.7 Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмаар тогтоосон аливаа зээлийн хязгаарлалт болон банкны зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлогоор тогтоосон зээл, зээлийн багцын

хязгаарлалтуудад тогтмол хяналт тавьж, хязгаараас хэтрүүлэлгүй банкны зээлийн үйл ажиллагааг эрхэлнэ.

- 3.8 Банкны эрсдэлийн удирдлагын нэгж нь энэ журмын 3.7-д заасан үйл ажиллагааны хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад улирал бүр тайлагнана.
- 3.9 Банкны эрсдэлийн удирдлагын нэгж энэ журмын 3.8-ын хүрээнд зөрчлийг илрүүлсэн тохиолдолд банкны Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэж, зөрчлийг арилгах хүрээнд шаардлагатай арга хэмжээг тухай бүр авахуулна.
- 3.10 Банк Монголбанкнаас баталсан Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмын хүрээнд өөрийн холбоотой этгээд, банкны ажилтан болон банкны ажилтны хамааралтай этгээдэд олгох зээлийн бодлоготой байх бөгөөд тус бодлоготой уялдуулан зохицуулсан дотоод журамтай байна.

ДӨРӨВ. Зээл олгоход баримтлах зарчим

- 4.1 Банк нь зээл олгоходоо зээл хүсэгчийн эрсдэлийн түвшинг үнэн, бодитой тогтооход шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулж, үнэлж, зээлдэгчийг таньж мэдсэний дараа шийдвэр гаргана.
- 4.2 Хэрэв банкны дотоод нөөц бололцоо аливаа зээл, зээлийн бүтээгдэхүүнийг олгох, судлах, хянахад дутагдалтай байх тохиолдолд тухайн зээлийг олгохоос татгалзана.
- 4.3 Банк зээл олгох шийдвэр гаргахдаа зээл хүсэгчийн талаарх дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж, холбогдох баримт бичгийг зээлийн хувийн хэрэгт хадгална. Үүнд:
 - 4.3.1 Зээлийн зорилго, зоиулалт, зээлийг эргэн төлөх эх үүсвэр;
 - 4.3.2 Зээл хүсэгчийн эрсдэлийн түвшин, барьцаа хөрөнгө болон тэдгээрийн эдийн засаг, бизнесийн орчны өөрчлөлтийн үеийн мэдрэмтгий байдлын судалгаа;
 - 4.3.3 Зээл хүсэгчийн зээлийн түүх, зээл хүсэх үеийн зээлийн эргэн төлөлтийн чадамж буюу зээл хүсэгчийн өнгөрсөн үеийн санхүүгийн байдал, ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөлд тулгуурлан хийсэн санхүүгийн тооцоолол;
 - 4.3.4 Хуулийн этгээдэд олгох зээлийн хувьд зээл хүсэгчийн бизнесийн туршлага, үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбарын ирээдүйн төлөв байдал, зээл хүсэгчийн тухайн зах зээлд эзлэх хувь, байр суурь;
 - 4.3.5 Зээлдэгчийн ирээдүйн эрсдэлийн түвшинг харгалзан боловсруулсан санал болгох зээлийн гэрээний нөхцөлүүд;
 - 4.3.6 Барьцаа, баталгаа, батлан даалт.

- 4.4 Банк зээл олгох шийдвэр гаргахдаа тухайн зээлийн эрсдэл болон түүнд харгалзах банкны хүлээгдэж буй өгөөж, байгуулж болзошгүй эрсдэлийн сангийн дүн зэргийг тооцоолж, харгалзан үзнэ.
- 4.5 Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлдэгчийг барьцаа хөрөнгөтэй байхыг шаардах боловч барьцаа хөрөнгө нь зээл олгох шийдвэр гаргах, зээлийн гэрээний нөхцөлийг тогтооход нөлөөлөхгүй.
- 4.6 Банк зээл олгох шийдвэрийг зээл хүсэгчийн зээлийг эргэн төлөх чадамжид тулгуурлан гаргана.
- 4.7 Хамтын санхүүжилттэй олгох зээлийн хувьд удирдагч болон оролцогч банкууд зээлийн эрсдэлийн судалгааг тус тусдаа, хараат бусаар хийж зээл олгох эсэх шийдвэрийг гаргана.
- 4.8 Банк зээлийн эргэн төлөлтийн хуваарийг зээл хүсэгчийн мөнгөн урсгалтай уялдуулан гаргах бөгөөд зээл, хүүгийн төлбөрийг сар бүр тогтмол төлүүлэхийг эрмэлзэнэ.
- 4.9 Банк зээлийн төлбөрийг хугацааны сүүл хэсэгт их дүнтэйгээр төлүүлэх (balloon payment) эсхүл хугацааны эцэст бүхэлд нь төлүүлэх (bullet payment) зээлийн эргэн төлөлтийн хуваарь хийхгүй байхыг эрмэлзэнэ.

ТАВ. Зээл олгоход тавигдах шаардлага, зээлийн хувийн хэргийн бүрдэл

- 5.1 Банк нь ерөнхий байдлаар болон зээлийн бүтээгдэхүүн бүрийн хувьд зээл олгоход тавигдах шалгуур, шаардлагыг тогтоож, холбогдох дотоод журам, зааварт нарийвчлан тусгана.
- 5.2 Зээлийн бүтээгдэхүүн бүрийн хувьд зээл олгоход тавигдах шалгуур, шаардлага, зээлийн хүү, хугацаа, зорилтот зээлдэгчийн бүлгийг банкны Шинэ бүтээгдэхүүний хороо (New product committee) батална.
- 5.3 Банк нь холбогдох судалгаа шинжилгээг хийн дотоод журмын дагуу зээл хүсэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоож, шаардлагыг хангасан этгээдэд зээл олгоно.
- 5.4 Банк нь зээл олгохоос өмнө болон олгосны дараа тодорхой давтамжийн дагуу зээлийн эрсдэлийн үнэлгээг хийж, зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоодог байна.
- 5.5 Банк нь зээлийн бүтээгдэхүүн тус бүрт эсхүл ерөнхий байдлаар барьцаалах боломжтой эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, барьцаалах эд хөрөнгөд тавигдах шаардлагыг тодорхойлно.
- 5.6 Банк барьцаа хөрөнгө авахад баримтлах дараах болон бусад шаардлагатай гэж үзсэн зарчмыг холбогдох дотоод журамдаа тусгасан байна. Үүнд:
 - 5.6.1 Зах зээлд эрэлттэй, борлуулах боломжтой хөрөнгө байх;

- 5.6.2 Түүх, урлаг соёлын үнэт зүйлс, шашны холбогдолтой эд зүйлс биш байх;
- 5.6.3 Монголбанкнаас баталсан Барьцаа хөрөнгийн үнэлгээний журмын дагуу үнэлсэн үнэлгээтэй байх бөгөөд зээлийн барьцааны үнэлгээ нь зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц байх;
- 5.6.4 Барьцаалах эрх хүчинтэй байх;

Зээлийн хувийн хэргийн бүрдэл

- 5.6 Банк зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд болон ерөнхий байдлаар зээлийн хувийн хэргийн бүрдэлд оруулах баримт материалын жагсаалтыг гаргаж, холбогдох дотоод журамд тусгасан байна.
- 5.7 Банк зээлийн хүсэлтийг хүлээж авахад дараах баримт материалыг зээл хүсэгчээс авч, зээлийн хувийн хэргийн бүрдэлд хавсаргана. Үүнд:
 - 5.7.1 Тотмол орлогын нотолгоо;
 - 5.7.3 Ирээдүйд орлогын эх үүсвэр тасрахгүй байх нотолгоо;
 - 5.7.4 Барьцаа хөрөнгийн баримт материал;
 - 5.7.4 Өмнөх зээл, зээлийн эргэн төлөлтийн түүх;
 - 5.7.5 Зээлийн зориулалт;
 - 5.7.6 Банкны дотоод журмаар тогтоосон бусад бүрдүүлэх баримт материал.
- 5.8 Хамтын санхүүжилттэй зээлийн хувийн хэргийн бүрдлийн шаардлагыг банк холбогдох дотоод журамд тусгайлан тодорхойлсон байна.
- 5.9 Зээлийн хувийн хэрэгт энэ журмын 5.7-д заасан баримт бичгээс гадна энэ журмын 4, 6 дугаар бүлгийн дагуу цуглуулсан мэдээлэл, хийсэн тооцоолол, судалгаа, зээлдэгчид зээл олгохоос өмнө болон дараа хийсэн зээлжих зэрэглэлийг тогтоохтой холбоотой хийсэн судалгаа, тооцоолууд, санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох бүх баримт бичгийг хавсаргана.
- 5.10 Банк энэ журмын 8 дугаар бүлгийн дагуу хийсэн зээлийн хяналттай холбоотой бүхий л цуглуулсан баримт бичиг, хийсэн, тооцоолол, судалгааг зээлийн хувийн хэрэгт хавсаргана.
- 5.11 Зээлийн хувийн хэрэгт зээл олгох шийдвэр гарах хүртэлх бүхий л үе шатанд гарсан дүгнэлт, санал, шийдвэрийг холбогдох баримт бичгийн хамт хавсаргана.
- 5.12 Банк зээлийн хувийн хэргийн бүрдлийг бүрэн гүйцэд бөгөөд **up to date** байлгана.

ЗУРГАА. Зээлийн судалгаа

- 6.1 Банк нь энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан хүсэлт, баримт материал дээр үндэслэн шаардлагатай тохиолдолд нэмэлт баримт нотолгоо цуглуулж, зээлийн судалгааг дараах байдлаар хийнэ:
- 6.1.1 Зээл хүсэгчийн мэдээлэл буюу анхдагч болон нэмэлт орлогын эх үүсвэрийг баталгаажуулах:
- 6.1.1.a Зээл хүсэгч нь иргэн байх тохиолдолд ажил олгогчийн талаарх мэдээлэл, анхдагч орлогын мэдээлэл буюу цалин, орлого, орлогын давтамж, орлогын төрөл, нэмэлт орлогын эх үүсвэрүүдийг баталгаажуулах;
- 6.1.2.б Зээл хүсэгч нь хуулийн этгээд байх тохиолдолд тухайн хуулийн этгээдийн санхүүгийн тайлангуудыг хүлээн авч, орлогыг баталгаажуулах.
- 6.1.2 Барьцаа хөрөнгийг шалгаж, баталгаажуулах;
- 6.1.3 Зээл хүсэгчийн мэдээллийг зээлийн мэдээллийн сан, улсын бүртгэлийн мэдээллийн сан, татварын мэдээллийн сан, шүүхийн шийдвэрийн сан гэх зэрэг мэдээллийн сангуудаас баталгаажуулах;
- 6.1.4 Зээл хүсэгчтэй хийх ярилцлага, газар дээрх судалгаа, бизнесийн хэтийн төлөв, үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбарын одоогийн нөхцөл байдал, ирээдүйн төлөв зэргийг судалж, зээл хүсэгчийн орлого, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаарх дүгнэлтийг гаргах;
- 6.1.5 Зээл хүсэгчийн орлогын түвшин, орлогын тогтвортой байдал, зардлын хэмжээ, өр-орлогын харьцаа болон бусад санхүү төлбөрийн чадварыг илэрхийлэх харьцааг тооцож, зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тодорхойлон байгуулах зээлийн гэрээний дагуу төлбөр хариуцагч нь зээл болон хүүгийн төлбөрөө төлж, барагдуулах боломжтой эсэх талаарх дүгнэлт гаргах.
- 6.2 Банк зээлийн судалгааг журам, зааврын дагуу, шаардлагатай бүхий л баримт материалыг үндэслэн үнэн бодитоор хийх бөгөөд зээлийн судалгаа хийх үйл явц, үр дүнг хянадаг шат дараалсан хяналтын тогтолцоотой байна.

ДОЛОО. Зээл олгох шийдвэр гаргах

- 7.1 Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, боловсронгуй байдал, зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, эрсдэлийн түвшнээс хамааран зээлийн хороо(д)-той байна.
- 7.2 Банкны зээл олгох шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь зээлийн хороо(д) байна.

- 7.3 Зээлийн хороо(д)-ын бүрэлдэхүүн, гишүүнчлэл, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны зарчим, горимыг холбогдох дотоод журам, зааварт нарийвчлан тусгасан байна.
- 7.4 Зээлийн хороо(д)-ын бүрэлдэхүүн нь зээлийн үйл ажиллагааны талаар туршлага, мэдлэгтэй, эрсдэлийг үнэлж, шийдвэр гаргах чадвартай мэргэжилтнүүд байна.
- 7.5 Зээлийн хороо(д)-ын бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг холбогдох дотоод журамд нарийвчлан тусгасан байна.
- 7.6 Зээлийн хороо(д) нь үйл ажиллагааны тайланг тодорхой давтамжийн дагуу бэлтгэж, Гүйцэтгэх удирдлагад тайлагнана.
- 7.7 Банкны холбоотой этгээдэд олгох зээлийг ТУЗ-ийн оролцоотой шийдвэрлэх бөгөөд Монголбанкнаас баталсан Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах тайлагнах, хяналт тавих журмын хүрээнд шийдвэрлэнэ.
- 7.8 Банк автомат програм ашиглан зээл олгох шийдвэрийг гаргадаг тохиолдолд холбогдох журам зааварт үйл ажиллагааны горим, шийдвэрлэх зээлийн бүтээгдэхүүний төрөл, хэмжээг заасан байна.
- 7.9 Энэ журмын 7.8-д заасан журам, зааврыг Эрсдэлийн удирдлагын хороо боловсруулж, ТУЗ батална.

НАЙМ. Зээлийн хяналт

- 8.1 Зээлийн эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх зорилгоор банк олгосон зээлд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 8.2 Зээлийг хянах болон зээлийн эрсдэлийг үнэлэх бүхий л үйл ажиллагаанд оролцох банкны ажилтнуудын үүрэг, хариуцлагыг холбогдох журамд тодорхой тусгасан байна.
- 8.3 Банк олгосон зээлийн эргэн төлөлт хийгдэж дуусах хүртэл зээлдэгчийн санхүүгийн байдалд тогтмол хяналт тавьж, зээлдэгчийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварыг үнэлэх санхүүгийн харьцааг тооцох, дүгнэх заавар, арга аргачлалтай байна.
- 8.4 Банк зээлийг хянах хүрээнд зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд зээлдэгчээс болон бусад эх үүсвэрээс цуглуулах мэдээлэл, баримт бичгийн төрөл, жагсаалтыг холбогдох журамд тодорхой зааж өгнө.
- 8.5 Банк зээл олгосны дараах хяналтыг сар бүр хийх бөгөөд Монголбанкнаас баталсан Актив ангиллын журмын дагуу ангилна.
- 8.6 Банк хуулийн этгээдэд олгосон зээлийн хувьд зээлдэгчийн санхүүгийн тайлангуудыг улирал бүр авч, санхүү, төлбөрийн чадварын шинжилгээг хийн ирээдүйн төлөвийг үнэлж, хяналтыг хийнэ.

- 8.7 Зээлийн хяналт хийсэн баримт материал буюу хяналтын хүрээнд цуглуулсан баримт материал, гаргасан үнэлгээ, дүгнэлтийг зээлийн хувийн хэрэгт тухай бүр хавсаргана.
- 8.8 Зээлийн хяналтыг хийх албан тушаалтан, түүний үүрэг, хариуцлага, хяналтыг хийх, эрсдэлийг үнэлэх аргачлалыг холбогдох журам, зааварт тусгасан байна.
- 8.9 Банк зээл олгосноос хойш зээлийн гэрээний хугацаанд барьцаа хөрөнгийг тодорхой давтамжийн дагуу Монголбанкнаас баталсан Барьцаа хөрөнгийн үнэлгээний журмын дагуу үнэлж, үнэ цэнийн өөрчлөлтийг тогтмол хянана.
- 8.10 Банк нь зээлийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг дараагийн шатны этгээдэд мэдэгдэх, арга хэмжээ авах тогтолцоотой байх бөгөөд холбогдох баримт материалыг тухай бүр зээлийн хувийн хэрэгт хавсаргана.

ЕС. Хяналт, тайлагнал

- 9.1 Банкны ТУЗ нь банкны эрсдэлийн аппетит, зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлогын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 9.2 Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны эрсдэлийн аппетит, зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, улирал бүр ТУЗ-д тайлагнана.
- 9.3 Банкны ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо нь жил бүр банкны эрсдэлийн аппетит, зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлогын зохистой, үр дүнтэй байдлыг үнэлж, дүгнэн ТУЗ-д тайлагнана.
- 9.4 Эрсдэлийн хорооны нэг гишүүн нь Аудитын хорооны гишүүн байна.
- 9.5 Аудитын хорооны дарга нь Эрсдэлийн хорооны гишүүн байна.
- 9.6 Банкны эрсдэлийн удирдлага хариуцсан захирал нь Эрсдэлийн хороонд шууд тайлагнадаг байна.
- 9.7 Банкны эрсдэлийн удирдлагын нэгж нь зээл олгосон шийдвэр, шийдвэр гаргах үйл явцад тогтмол хяналт тавьж, Эрсдэлийн хороонд тайлагнана.
- 9.8 Зээл олгох шаардлагыг хангаагүй эсхүл зээлийн эрсдэлийн аппетит, зээлийн бодлогоор тогтоосон хязгаарлалтууд болон Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан журмаар тогтоосон хязгаарлалтуудыг зөрчсөн зээлүүдэд банкны Эрсдэлийн удирдлагын нэгж тогтмол хяналт тавьж, сар бүр Эрсдэлийн хороонд тайлагнана.
- 9.9 Банк энэ журмын 9.7 болон 9.8-ын дагуу хийсэн хяналттай холбоотой бүхий л судалгаа, баримт бичгийг зээлийн хувийн хэрэгт хавсаргана.

- 9.10 Банкны Эрсдэлийн удирдлагын нэгж зээлийн хувийн хэргийн бүрдлийн бүрэн гүйцэд байдалд хяналт тавьж ажиллана.